



ТӨРИЙН АУДИТЫН ЗӨВЛӨМЖ, ДҮГНЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТ

МОНИТОРИНГИЙН ТУХАЙ

Төрийн аудитын байгууллагаас 2016-2020 онд аудит хийж гаргасан зөвлөмж, дүгнэлт, актын хэрэгжилт тэдгээрийн ил тод байдалд Үнэн Хатамж ТББ-ын хийсэн ажиглалт, мониторингийн товч үр дүнг танилцуулж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг Үнэн Хатамж ТББ-ын <http://sinaudit.mn> вэб сайт, “Сайн аудит” Facebook, “Аудитын тухай ярилцъя” Twitter хуудаснаас үзнэ үү.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ОУНББС	Олон улсын нягтлан бодох бүртгэлийг стандарт
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ШДНЦХ	Шилэн дансны нэгдсэн цахим хуудас

МОНИТОРИНГИЙН АРГАЧЛАЛ


Төрийн аудитын тухай хуулийн дагуу Төрийн аудитын байгууллагаас (i) санхүүгийн тайлангийн, (ii) гүйцэтгэлийн, (iii) нийцлийн гэсэн гурван төрлийн аудит хийж дүгнэлт, зөвлөмж гаргадаг билээ. Энэхүү мониторингоор Төрийн аудитын байгууллагаас төсөв захирагчдад өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн мэдээллийг Төрийн аудитын байгууллага болон хэрэгжүүлж буй төрийн байгууллагуудын албан ёсны мэдээнд үндэслэн гаргасан болно. Мониторингид 2016-2019 онд Аудитын газраас хийсэн шалгалтын 996 зөвлөмж, 302 дүгнэлт, 86 акт, 186 албан шаардлагыг хамрууллаа. Түүнчлэн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг мөн авч үзсэн болно.

МОНИТОРИНГИЙН ДҮН

АУДИТЫН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЕРӨНХИЙ ДҮН

Аудитын зөвлөмжийн хэрэгжилт 2018 онд 81.1 хувь байсан бол 2019 онд 81.9 болж 0.8 хувиар өсжээ. 2010-2019 онд гаргасан Аудитын зөвлөмжийн биелэлтийг харахад 2010, 2013 онд хамгийн сайн буюу 100 хувь биелж байсан бол 2012 онд хамгийн бага буюу 67 хувьтай байжээ. Сүүлийн жилүүдэд аудитын зөвлөмжийн хэрэгжилт сайжрах хандлагатай байна.

График 1. Нийт зөвлөмжийн биелэлт, 2010-2019 он



Зөвлөмжийн хэрэгжилтийг аудитын төрлөөр авч үзвэл, санхүүгийн аудит 80-аас дээш хувьтай буюу хэрэгжилт сайн байгаа бол нийцлийн болон гүйцэтгэлийн аудитын хэрэгжилт сул буюу 40-60 хувьтай байна. 2018 онд гүйцэтгэлийн аудит 52.9 хувь,

нийцлийн аудит 51.4 хувийн хэрэгжилттэй байсан бол 2019 онд гүйцэтгэлийн аудит 54.1 хувь, нийцлийн аудит өмнөх оны үлдэгдэлтэй нийлээд 84.8 хувь болж, зөвлөмжийн хэрэгжилт сайжирсан дүн харагдаж байна.


АУДИТААР АВСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЕРӨНХИЙ ДҮН

Төрийн аудитын байгууллага хийж гүйцэтгэсэн хяналтаараа төлбөрийн акт тогтоох, албан шаардлага өгөх, зөвлөмж өгөх зэрэг арга хэмжээг авдаг. Төрийн аудитын байгууллагаас 2010-2019 онд аудит хийж, зөвлөмжийн мөрөөр авсан арга хэмжээний биелэлтэд хийсэн дүн шинжилгээний товч дүнг доор харуулав.

2010-2019 оны аудитын тайлангаас харахад,

2014 онд хамгийн олон буюу 10,101 төлбөрийн акт тогтоож байсан бол 2018 онд мөн 9,083, 2019 онд 7,524 акт тогтоожээ. Актыг мөнгөн дүнгээр авч үзвэл, 2012 онд 70.5 тэрбум төгрөг байсан нь хамгийн өндөр дүн байсан ба үүнээс хойш буурсан боловч 2018 онд 57.4 тэрбум төгрөг болж өсжээ. Энэ дүн 2019 онд 19.2 тэрбум төгрөг болж буурчээ.

График 2. Аудитаар тогтоосон нийт төлбөрийн акт, 2010-2019 он



Эх сурвалж: Төрийн аудитын жилийн тайлангууд

Төлбөрийн акт нь төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэж буй аудитын явцад илэрсэн төлбөрийг нөхөн төлүүлэхэд чиглэсэн заавал биелүүлэх шинжтэй захиргааны акт юм. Дараах тохиолдолд төлбөрийн акт тогтоодог. Үүнд:

- Төрийн өмч хөрөнгийг үндэслэлгүйгээр бусдад хандивласан, үнэ төлбөргүй шилжүүлсэн;
- Төрийн болон орон нутгийн өмчтэй холбоотой орлого дутуу төвлөрүүлсэн, эсвэл төвлөрүүлээгүй;
- Цалин хөлс, шагнал, урамшуулал тэтгэмж зөрүүтэй тооцож олгосон;
- Татварын болон татварын бус төсвийн

орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн, эсвэл төвлөрүүлээгүй;

- Норм нормативыг хэтрүүлэн зарцуулсан;
- Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгийг дутаасан, үрэгдүүлсэн гэх мэт.

Албан шаардлагын хувьд 2010-2019 оны аудитын тайлангаас харахад 2015 онд хамгийн олон буюу 3,195 албан шаардлага өгсөн байсан бол 2017 онд 2,152 болж 1043-аар буурчээ. Харин 2019 онд 2,897 болж дахин өссөн байна. Албан шаардлагыг мөнгөн дүнгээр авч үзвэл, 2015 онд хамгийн өндөр буюу 5.5 их наяд төгрөг байсан бол 2019 онд 1.9 их наяд төгрөг болж буурчээ.

График 3. Аудитаар өгсөн нийт албан шаардлага, 2010-2019 он



Эх сурвалж: Төрийн аудитын жилийн тайлангууд

Албан шаардлага нь төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэж буй аудитын алдаа зөрчлийг таслан зогсоож, зохих арга хэмжээ авахыг шалгуулж буй этгээдэд хариуцуулж даалгасан заавал биелэгдэх шинжтэй захиргааны акт юм. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй;
- Өмч хөрөнгийг бусдад зүй бусаар ашиглуулсан;

- Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй, эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн;
- Төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн,
- Төсвийг зориулалт бусаар зарцуулсан;
- Авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- Байгуулсан гэрээ хэлцэл холбогдох дүрэм журмыг баримтлаагүй гэх мэт.

АУДИТААР АВСАН АРГА ХЭМЖЭЭ (АУДИТЫН ТӨРЛӨӨР)

Төрийн аудитын байгууллагаас хийсэн санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудитын хүрээнд авсан арга хэмжээ, тэдгээрийн биелэлт 2017-2019 онд ямар түвшинд байгааг аудитын төрөл тус бүрээр нь авч үзлээ. Үүний үр дүнг доор харуулав.

Санхүүгийн аудит


“Санхүүгийн тайлангийн аудит”-аар шалгуулж буй этгээд санхүүгийн тайлангаа холбогдох хууль тогтоомж, стандарт, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актын шаардлагад нийцүүлэн үнэн зөв, шударгаар тайлагнасан эсэхэд аудит хийж

баталгаажуулдаг юм. Санхүүгийн аудитаар “Зөрчилгүй”, “Хязгаарлалттай”, “Сөрөг санал дүгнэлт”, “Дүгнэлт гаргахаас татгалзсан” гэсэн дөрвөн төрлийн дүгнэлт өгдөг. Санхүүгийн аудитын дүнг оноор харуулбал:

Зураг 1. 2017 оны санхүүгийн аудитын дүн



Төлбөрийн акт 13.3 тэрбум төгрөг
Албан шаардлага 2,150.4 тэрбум төгрөг
Залруулсан зөрчил 2,132.7 тэрбум төгрөг




2017 онд санхүүгийн аудитад 3,179 байгууллагыг хамруулан 13.3 тэрбум төгрөгийн акт, 2,150.4 тэрбум төгрөгийн албан шаардлага тавьснаас 2,132.7 тэрбум төгрөгийн зөрчлийг залруулсан байна. Санхүүгийн аудитын дүгнэлтийн 2,848 буюу 89.6 хувь нь зөрчилгүй, 294 нь буюу 9.2 хувь нь хязгаарлалттай, 22 буюу 0.7 хувь нь сөрөг санал дүгнэлт эзэлж, 15 буюу 0.5 хувьд нь дүгнэлт гаргахаас татгалзжээ.

Зураг 2. 2018 оны санхүүгийн аудитын дүн



Төлбөрийн акт 10.6 тэрбум төгрөг
Албан шаардлага 905.6 тэрбум төгрөг
Залруулсан зөрчил 12,109.9 тэрбум төгрөг




2018 онд санхүүгийн аудитаар 3,806 байгууллагыг хамруулан 10.6 тэрбум төгрөгийн акт, 905.6 тэрбум төгрөгийн албан шаардлага, 14 их наяд төгрөгийн зөрчил илрүүлж, 12.1 их наяд төгрөгийн зөрчлийг арилгуулжээ.

Зураг 3. 2019 оны санхүүгийн аудитын дүн



Төлбөрийн акт 14.1 тэрбум төгрөг
Албан шаардлага 523.6 тэрбум төгрөг
Залруулсан зөрчил 1,535.9 тэрбум төгрөг



2019 онд 3,958 байгууллагыг хамруулан 14.1 тэрбум төгрөгийн акт, 523.6 тэрбум төгрөгийн албан шаардлага, 4.2 их наяд төгрөгийн зөрчил илрүүлж, 1.5 их наяд төгрөгийн зөрчил арилгуулсан байна.

Гүйцэтгэлийн аудит

“Гүйцэтгэлийн аудит” гэдэг нь шалгуулж буй этгээдийн бодлого, тогтолцоо, үйл ажиллагаа, чиг үүргийн хэрэгжилт, хөтөлбөр,

төсөл, арга хэмжээний үйл явц, үр дүн, гүйцэтгэлд аудит хийх үйл ажиллагаа юм.

Зураг 4. 2017 оны гүйцэтгэлийн аудитын дүн



2017 оны гүйцэтгэлийн аудитаар нийт 4,307 байгууллагыг хамруулж, 999 зөвлөмж, 4.5 тэрбум төгрөгийн төлбөрийн акт, 89.2 тэрбум төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн байна. Зөрчлийн төрлөөр авч

үзвэл, дотоод хяналттай холбоотой зөрчил хамгийн их буюу 92 хувийг эзэлж, бусад зөрчил харьцангуй бага буюу 1-2 хувь эзэлж байна.

Зураг 5. 2018 оны гүйцэтгэлийн аудитын дүн



2018 оны гүйцэтгэлийн аудитаар нийт 6,189 байгууллагыг хамруулж, 1,318 зөвлөмж, 34.1 тэрбум төгрөгийн төлбөрийн акт, 1,019.0 тэрбум төгрөгийн албан шаардлага хүргүүлжээ. Зөрчлийн төрлөөр авч үзвэл,

хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил хамгийн их буюу 53 хувийг эзэлж, дотоод хяналт, арвилан хэмнэхтэй холбоотой зөрчил тус бүр 7 хувь, бусад зөрчил 30 хувийг эзэлж байна.

Зураг 6. 2019 оны гүйцэтгэлийн аудитын дүн



2019 оны гүйцэтгэлийн аудитаар нийт 3,364 байгууллагыг хамруулж, 1,122 зөвлөмж, 2.1


тэрбум төгрөгийн төлбөрийн акт, 986 тэрбум төгрөгийн албан шаардлага хүргүүлжээ.

Нийцлийн аудит

“Нийцлийн аудит”-д шалгагдагч этгээдийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа төрийн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой

хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актын хэрэгжилт, тэдгээрийн нийцлийн аудитыг хамааруулдаг.

Зураг 7. 2017 оны нийцлийн аудитын дүн



2017 оны нийцлийн аудитад нийт 5,494 байгууллагыг хамруулж, 821 зөвлөмж, 4.6 тэрбум төгрөгийн төлбөрийн акт, 298.3 тэрбум төгрөгийн албан шаардлага хүргүүлжээ. Зөрчлийн төрлөөр авч үзвэл, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

зөрчил хамгийн их буюу 75 хувийг эзэлж байна. Бүртгэл, тайлагналтай холбоотой зөрчил 17 хувийг эзэлж байгаа бол дотоод хяналт, арвилан хэмнэхтэй холбоотой зөрчлүүд тус бүр 1-2 хувийг эзэлж байна.

Зураг 8. 2018 оны нийцлийн аудитын дүн



2018 оны нийцлийн аудитад нийт 8,737 байгууллагыг хамруулж 822 зөвлөмж, 12.7 тэрбум төгрөгийн төлбөрийн акт, 278.1 тэрбум төгрөгийн албан шаардлага хүргүүлжээ. Зөрчлийн төрлөөр авч үзвэл, хууль тогтоомжийн хэрэгжилттэй

холбоотой зөрчил хамгийн их буюу 74 хувийг эзэлж байна. Арвилан хэмнэх, үр нөлөөг сайжруулах зөрчил 18 хувь, бүртгэл тайлагнал болон дотоод хяналт, худалдан авалттай холбоотой зөрчлүүд тус бүр 2 хувийг эзэлж байна.

Зураг 9. 2019 оны нийцлийн аудитын дүн



2019 оны нийцлийн аудитад нийт 7,399 байгууллагыг хамруулж 866 зөвлөмж, 3.0 тэрбум төгрөгийн төлбөрийн акт,

482.3 тэрбум төгрөгийн албан шаардлага хүргүүлжээ.

АУДИТЫН ТАЙЛАН, ДҮГНЭЛТЭД ТУСГАГДСАН АСУУДЛААР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ИЛ ТОД БАЙДАЛ

Төрийн аудитын дүгнэлт, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээг хуулийн хугацаанд цахимаар ил тод болгож, иргэдэд нээлттэй хүргэх нь Төсвийн Ерөнхийлөн Захирагч (ТЕЗ) нарын үүрэг юм. Төрийн байгууллагууд Шилэн дансны тухай хуулийн 6.1.5-д зааснаар ТЕЗ-ийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь

тухайн жилийн 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор; аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 7 дугаар сарын 1-ний өдрийн дотор тогтмол мэдээлнэ гэсэн заалтын дагуу мэдээллээ байршуулах ёстой.

Хэдий тийм боловч дээрх заалтын хэрэгжилт хангалтгүй, цаг хугацаандаа хэрэгжихгүй

байна. 2018 онд Төрийн Аудитын дүгнэлт, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээг цаг тухайд нь шилэн дансны цахим хуудаснаа ил тод болгоогүй 6, хугацаа хоцорч байршуулсан 32 ТЕЗ байсан ба

хугацаандаа мэдээллээ оруулсан нь 15 байв. Мэдээллээ цаг хугацаанд нь ил тод болгоогүй 38 ТЕЗ нийт төсвийн захирагчийн 59 хувь, огт мэдээлээгүй нь 11 хувийг эзэлж байна.

ХҮСНЭГТ 1. ТӨРИЙН АУДИТЫН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖИЙН ДАГУУ АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭГ ТЕЗ НАР ИЛ ТОД БОЛГОСОН БАЙДАЛ

	Нийт ТЕЗ-ийн тоо	Огт ил тод болгоогүй		Хугацаа хоцорч байршуулсан		Хугацаандаа мэдээллээ оруулсан	
		ТЕЗ-ийн тоо	Нийт ТЕЗ-д эзлэх хувь	ТЕЗ-ийн тоо	Нийт ТЕЗ-д эзлэх хувь	ТЕЗ-ийн тоо	Нийт ТЕЗ-д эзлэх хувь
2018 он	53	6	11%	32	59%	15	30%
2020 он	53	4	7%	27	50%	22	43%

Эх сурвалж: Шилэн дансны цахим хуудас

2019 онд Төрийн аудитын дүгнэлт, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээг цаг тухайд нь шилэн дансны цахим хуудсанд ил тод болгоогүй 12 ТЕЗ байсан нь нийт ТЕЗ-дын 22 хувь байв. Бид тэдгээр ТЕЗ-дад албан тоот явуулснаар ихэнх нь мэдээллээ ил болгосныг дурдах нь зүйтэй. 2020 оны 8 дугаар сарын 30-ны байдлаар 53 ТЕЗ-аас 30 нь шилэн дансанд

цаг хугацаанд нь мэдээллээ байршуулаагүй байгаа нь нийт ТЕЗ-ийн 55 хувь болж байна. 2020 оны төгсгөлд ТЕЗ-дын хувьд хугацаандаа байршуулсан 22, хугацаа хоцорч байршуулсан 27, мэдээллээ огт байршуулаагүй нь дөрөв болсон. Ийнхүү мэдээллээ ил тод болгоогүй нь нийт ТЕЗ-ийн 7 хувь, хугацаандаа мэдээлээгүй нь 50 хувь байна.

АУДИТААС ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАЖ, ТҮҮНИЙ ДАГУУ ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Мониторингид Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар өгсөн

зөвлөмжийн хэрэгжилтийг мөн хамруулсан ба үр дүнг доор үзүүлэв.

Зураг 10. Шилэн дансны тухай хуулийн 2018 оны хэрэгжилтэд хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт



Өмнөх аудитудаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн хэдий ч зөвлөмжийн биелэлт 43.7 хувь байна.



2017 онд хийсэн аудитаар нийт 72 байгууллагад хариуцлага тооцуулах, 415 зөрчил арилгуулах хугацаатай албан шаардлага хүргүүлсэн нь бүрэн хэрэгжсэн байна.



Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 3.1.5-д заасан аж ахуйн нэгж, байгууллагуудтай байгуулах гэрээнд ШДНЦХ-д хуульд заасан мэдээллийг байршуулах үүргийг тусгаж, биелэлтээр санхүүжилт олгох арга хэмжээ авах зөвлөмж хэрэгжээгүй байна.



Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжүүдийг бүрэн хэрэгжүүлж, үйл ажиллагаандаа хэвшил болгоогүйгээс өмнөх аудитаар илэрсэн зөрчил давтан гарсаар байна.

Эх сурвалж: Үндэсний аудитын газрын тайлан

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн 2018 оны аудитаар өмнөх аудитуудаар төсөв захирагчдад өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллага шалгаад дараах дүгнэлт гаргажээ. Үүнд:

- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн өмнөх аудитуудаар өгсөн албан шаардлагыг байгууллагууд бүрэн хэрэгжүүлсэн хэдий ч зөвлөмжийн биелэлт 43.7 хувьтай байна.
- Төрийн аудитын байгууллагаас 2017 онд хийсэн аудитаар илэрсэн зөрчилд тухай бүр залруулга хийлгэж ажилласнаас гадна нийт 72 байгууллагад хариуцлага тооцуулах, 415 зөрчил арилгуулах хугацаатай албан шаардлага хүргүүлсэн нь бүрэн хэрэгжжээ.
- Үндэсний аудитын газраас Шилэн дансны тухай хуулийг Төсвийн тухай хуульд нийцүүлэх, тайланд дурдагдсан хуульчлах шаардлагатай асуудлуудыг судалж шийдвэрлэх, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг Шилэн дансны тухай хууль болон Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх, тайланд дурдагдсан журамлах шаардлагатай асуудлуудыг судалж шийдвэрлэх зөвлөмжийг Монгол Улсын Ерөнхий сайдад өгсөн билээ. Дээрх зөвлөмжийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 154

дүгээр захирамжаар Шилэн дансны тухай хууль болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

- Харин Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 3.1.5-д заасан аж ахуйн нэгж, байгууллагуудтай хийх гэрээнд ШДНЦХ-д хуульд заасан мэдээллийг байршуулах үүргийг тусгаж, биелэлтээр санхүүжилт олгох арга хэмжээ авах зөвлөмж хэрэгжээгүй байна.
- Сангийн сайдад ТЕЗ-ийн дотоод аудитын албыг Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих арга зүйн удирдлагаар хангаж ажиллах зөвлөмж өгсөн бөгөөд тус зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээ авч ажиллажээ.
- ШДНЦХ-д хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.3-т хамаарах татан буугдсан, давхар цэс үүсгэгдсэн, 3 дугаар зүйлийн 3.1.4-3.1.5-д хамаарах үйл ажиллагаа явуулдаг эсэх нь тодорхойгүй аж ахуйн нэгж, байгууллага (ААНБ)-ын цэсийг цэгцлэх зөвлөмж өгсөн. Сангийн яамнаас дээрх зөвлөмжийн дагуу Шилэн данс хөтлөөгүй байгууллагуудын жагсаалтыг хянаж, хариу ирүүлэх талаар ТЕЗ нарт системийн дотоод захиагаар хүргүүлсэн боловч үр дүн гараагүй байна.
- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжүүдийг бүрэн хэрэгжүүлж, үйл ажиллагаандаа хэвшил болгоогүйгээс илэрсэн зөрчил давтагдсаар байна.

Зураг 11. Шилэн дансны тухай хуулийн 2019 оны хэрэгжилтэд хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

2019 онд нийт 48 байгууллагад хариуцлага тооцуулах, 519 зөрчил арилгуулах хугацаатай албан шаардлага хүргүүлсэн нь 99.6 хувийн биелэлттэй байна.

Өмнөх аудитаар улсын хэмжээнд 23 байгууллагад өгсөн 119 зөвлөмжөөс 106 нь хэрэгжсэн ба 12 зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байна.

Монгол Улсын Ерөнхий сайдад 6 зөвлөмж хүргүүлснээс өмнөх жилүүдэд гүйцэтгэсэн аудитын тайланд тусгасан журамлах шаардлагатай асуудлуудыг судалж шийдвэрлэх ажлыг эрчимжүүлэх агуулга бүхий 1 зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байна.

Сангийн сайдад 9 зөвлөмж хүргүүлсний дагуу ажлын төлөвлөгөөг батлан ажиллаж, 90 хувийн биелэлттэй хэрэгжүүлжээ.

Өмнөх аудитуудаар өгсөн албан шаардлагын хэрэгжилт сайн байгаа боловч зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь 2019 онд мөн давтагдав. Тухайлбал, Төрийн аудитын байгууллагаас дараах дүгнэлтийг өгчээ. Үүнд:


- Сүхбаатар аймгийн ТЕЗ-д хамаарах хоёр байгууллага зөрчлийг арилгаагүй байсан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д заасны дагуу холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулах тухай албан шаардлага дахин хүргүүлжээ.
- УАГ-аас Ерөнхий сайдад 6 зөвлөмж хүргүүлснээс Шилэн дансны тухай хууль, холбогдох журмыг боловсронгуй болгох, өмнөх жилүүдэд гүйцэтгэсэн аудитын тайланд тусгасан журамлах шаардлагатай асуудлуудыг судалж шийдвэрлэх ажлыг эрчимжүүлэх агуулга бүхий 1 зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байна.
- Тухайн зөвлөмжийн хүрээнд Ерөнхий сайдын 2018 оны 154 дүгээр захирамжаар Шилэн дансны тухай хууль болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсан хэдий ч холбогдох ажлын гүйцэтгэл хангалтгүй байна.
- Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны А/210 дугаар тушаалаар “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулах дэд ажлын хэсэг томилогдон ШДНЦХ-ыг хөгжүүлэх, журмын шинэчлэлийн төслийг боловсруулах ажлыг 2020 онд хэрэгжүүлж дуусгахаар нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, 70 орчим хувийн гүйцэтгэлтэй ажиллаж байна. Энэ нь төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэсэн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитуудын нэг үр дүн юм. Иймд өмнөх онуудад гүйцэтгэсэн аудитын тайланд тусгасан хууль, журмын зохицуулалттай холбоотой, эрх зүйн зөрчил бүхий асуудлыг дээрх ажлын хэсгийн хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгуулах арга хэмжээ авч ажиллах шаардлагатай гэж үзлээ.

Төслийн хүрээнд бид төрийн аудитын дүгнэлт, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний ил тод байдлыг дээшлүүлэх талаар төрийн байгууллагуудад чиглэсэн үйл ажиллагаа явууллаа. Тухайлбал, 2019 онд Төрийн аудитын дүгнэлт, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээг цаг тухайд нь шилэн дансны цахим хуудаснаа ил тод болгоогүй 12 ТЕЗ 2019 оны 7 дугаар сард албан тоот явуулжээ. Үүнд:

1. Монгол Улсын Шадар Сайд;
2. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга;
3. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга;
4. Үндсэн хуулийн цэцийн дарга;
5. Монгол Банкны Ерөнхийлөгч;
6. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд;
7. Гадаад хэргийн сайд;
8. Дорноговь аймгийн засаг дарга;
9. Завхан аймгийн засаг дарга;
10. Өвөрхангай аймгийн засаг дарга;
11. Төв аймгийн засаг дарга;
12. Ховд аймгийн засаг дарга.

Албан бичгийн дагуу 2019 оны 7 дугаар сарын 20-ны өдрөөс Монгол банк, Өвөрхангай аймгаас холбогдож, арга хэмжээ авснаа мэдэгдсэн ба ЗГХЭГ, Монгол Улсын Шадар Сайдаас хариу албан тоот ирж, Ховд аймаг ТЕЗ солигдсон шалтгаанаар албан тоотыг буцаасан байна. 2019 оны төгсгөлд ихэнх ТЕЗ шилэн дансанд мэдээллээ байршуулжээ.

Зураг 12. ЗГХЭГ-аас 2019 онд ирүүлсэн хариу албан тоот



Уг мэдээлэл шилэн дансны цахим хуудаснаа 2020 оны 7 дугаар сарыг 1 болон 15-ны байдлаар огт тавигдаагүй байсан ба 2020 оны 8 дугаар сарын 30-ны байдлаар 24 ТЕЗ мэдээллээ байршуулсан. Нийт 54 ТЕЗ байдгаас 30 нь шилэн дансанд мэдээллээ байршуулаагүй ба энэ нь нийт ТЕЗ-ийн 55 хувь юм. Түүнчлэн, мэдээллийн ил тод байдал буурахад УИХ-ын сонгуулийн нөлөө их байсан гэж судлаачдын зүгээс үзэж байна.

Ховд аймгийн Засаг дарга, Зам, тээвэр хөгжлийн сайд, Гадаад хэргийн сайд, ЗГХЭГ-ын дарга нар 2017, 2018, 2019 онд

гурван жил дараалан, УИХ-ын дарга, Сангийн сайд, Нийслэл, Дархан-Уул, Завхан, Өмнөговь, Сүхбаатар аймгийн Засаг дарга нар 2018, 2019 онд хоёр жил дараалан мэдээллээ нийтлээгүй байгаа нь иргэд хяналт тавих боломжийг хааж байна гэсэн үг юм.

Мэдээллээ цаг хугацаандаа оруулахаас гадна аудитын дүгнэлт, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээг ил тод болгох нь мөн ач холбогдолтой. 2019 оны байдлаар Монгол банк, Авлигатай тэмцэх газар аудитын мэдээг оруулсан ч авч хэрэгжүүлсэн арга хэмжээг оруулаагүй байна.

ТӨРИЙН АУДИТЫН ЗӨВЛӨМЖ, ДҮГНЭЛТИЙН АГУУЛГЫН ДАВТАГДАЛ

Төрийн аудитаар илэрсэн алдаа дутагдал жил бүр давтан гарч байгаа нь аудитын зөвлөмж, дүгнэлтийн хэрэгжилт сул

байгаатай шууд холбоотой. Эдгээрээс зарим жишээг дор дурдъя.

Зураг 13. Төрийн аудитын давтагдсан зөвлөмж, дүгнэлт: Санхүүгийн зохицуулах хорооны дарга

2017 он	2018 он	2019 он
1. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг зөрчсөн байна.	1. Тус байгууллага үндсэн үйл ажиллагааны орлогыг үндэслэлтэй төлөвлөдөггүй. 2. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 7.2 сая төгрөгийг цалингийн зардалд зориулалт бусаар зарцуулсан.	1. Тус байгууллага нь үндсэн үйл ажиллагааны орлогыг 822.4 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 1,299.2 сая төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн нь Төсвийн орлогыг үндэслэлтэй төлөвлөөгүй. 2. Ахмадын сангаас нийт 3,555.0 мянган төгрөгийн 6 төрөлт тэмцээн уралдаан зохион байгуулж, сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан.

Санхүүгийн зохицуулах хороонд 2017-2019 онд гурван жил дараалан төсвийг үр ашигтай төлөвлөж, зарцуулах чиглэлээр зөвлөмж өгсөн байгаа нь төсөв шаардагдах

ажил биш харин “сэтгэл гаргаж” ажлаа хийхэд биелэгдэхээр, давтан гаргахгүй байж болох зөрчил байв.

Зураг 14. Төрийн аудитын давтагдсан зөвлөмж, дүгнэлт: Монгол Улсын Ерөнхий Сайд

2018 он			2019 он	
Гэрээний үр дүнг харгалзалгүй 8,963.5 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгож төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан.	Тайлант онд гадаад албан томилолтоор ажиллахдаа нийт 11,628.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан.	Тайлант онд нийт 28,764.6 мянган төгрөгийн бараа, үйлчилгээг харьцуулалтын үнийн арга хэрэглэлгүй шууд худалдан авсан.	ТҮЦ машины засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгслийн үнэ, бэлэн мөнгө уншигчийн машин худалдан авалтад тендэр зарлаагүй.	Төсвийн төвлөрүүлэн болон шууд захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд санхүүгийн тайлан, улсын төсвийн орлого төвлөрүүлэлт, төсвийн төлөвлөлт, зардлын гүйцэтгэл, худалдан авах ажиллагаанд тавих дотоод хяналтаа сайжруулах.

Монгол Улсын ерөнхий сайдад өгсөн төсвийн үр ашгийг дээшлүүлэх, хяналт

сайжруулах зөвлөмж 2020 онд мөн давтагджээ.

Зураг 15. Төрийн аудитын давтагдсан зөвлөмж, дүгнэлт: Сэлэнгэ аймаг

2016 он	2017 он	2016 он	2016 он
<p>1. Тариалан эрхлэлтийг дэмжих сантай техник тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн тооцоо нийлж, өр төлбөр данснаас хасуулах ажлыг зохион байгуулах.</p> <p>2. Төсөвт зохицуулалт хийгдээгүй байхад зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулдаг зөрчлийг арилгах.</p>	<p>1. Тариалан эрхлэлтийг дэмжих сантай техник тоног төхөөрөмж хүлээлгэн өгсөн тооцоо нийлж, өр төлбөрийг данснаас хасуулах ажлыг зохион байгуулах.</p> <p>2. Төсвийн тухай хуулийн дагуу орлого бүрдүүлж, гүйцэтгэлд хяналт тавих. Татварын орлогын гүйцэтгэлийг үнэн зөвөөр тайлагнах.</p>	<p>1. Татварын орлогын гүйцэтгэлийг үнэн зөв бүртгэж, гүйцэтгэлийг бодитой тайлагнаж байх.</p>	<p>1. Батлагдсан төсвийг хэмнэлттэй, үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулж, төсвийг зохистой удирдан өр, авлага үүсгэхгүй ажиллахад онцгойлон анхаарч, үр нөлөө бүхий дотоод хяналтыг хэрэгжүүлэх.</p> <p>2. Төсвийн тухай хуулийн дагуу төсөвт байгууллагын өөрийн орлогыг бүрэн бүрдүүлж, гүйцэтгэлийг үнэн зөвөөр тайлагнах.</p> <p>3. Дээд газрын зөвшөөрөлгүй зардлыг бүлэг хооронд гүйлгэн зарцуулахгүй байх.</p>

Сэлэнгэ аймаг дөрвөн жил дараалан төсвийн орлогын гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнах, зардал гүйлгэн зарцуулахгүй байх зөрчил гаргасан ба энэ нь засаж залруулахад хөрөнгө мөнгө шаардах ажил биш, анхааран ажиллахад залруулж болох зөрчил байв.

Зөрчил жил дараалан давтан гарсан бусад жишээнээс мөн дурдвал:

- Улсын Ерөнхий прокурор: 2016, 2017 онд дотоод аудит ажиллуулах, ажлыг нь сайжруулах зөвлөмж;
- Шүүхийн Ерөнхий зөвлөл: 2017, 2018 онд Санхүүгийн тайлангийн нэгтгэлийг хариуцлагатай, чанартай хийх зөвлөмж;
- Дундговь аймаг: 2016, 2017, 2018 онд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг (НБББББ) боловсруулж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх;
- Орхон аймаг: 2017, 2019 онд авлага, өр төлбөргүй ажиллах талаар зэрэг байна.

Төсвийн шууд захирагчдын хувьд зөвлөмжийн хэрэгжилт харьцангуй сайн байдаг ба төсвийн хэмжээндээ ч зарцуулалт сайн, акт тогтооход төлөлт харьцангуй сайн байв. Харин ТЕЗ-дын хувьд хэрэгжилт сул байгаа нь ажиглагдлаа. Жишээ нь, жил бүр улсын төсвийн төлөвлөлтөд аудит хийж, Ерөнхий сайд, Сангийн сайдад дараах зөвлөмжийг давтан өгчээ. Үүнд:

- Орлого бодитой төлөвлөх;
- Зардал эрэмбэлэх;
- Хөрөнгө оруулалтын өртөгт хязгаар тогтоож, шалгуур тогтоох;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, хяналт тавих.

ТЕЗ-дад шилэн дансны хэрэгжилтийг сайжруулах зөвлөмж өгдөг ч жил дараалан хэрэгжихгүй байна.

МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН АУДИТЫН ДҮГНЭЛТ

“Монгол Улсын Ерөнхий аудитор төрийн санхүү, төсөв, нийтийн өмчийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөө гарахуйц төлөвлөх, хуваарилах, ашиглах, захиран зарцуулахад хамаарах аливаа асуудлаар

санал, зөвлөмж бэлтгэж, УИХ-д танилцуулж болно” гэсэн “Төрийн аудитын тухай” хуулийн 33.4 дэх заалт бий. Гэсэн хэдий ч энэхүү заалтын хэрэгжилт сул байна. Төрийн аудитын байгууллагаас Төсвийн

тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар ерөнхий зөвлөмж өгдөг ба энэ нь жил бүр давтагддаг. Зөвлөмжид яг ямар арвилан

хэмнэлт, хуваарилалт хийх талаар тодорхой тусгадаггүй. Үүнийг доорх дүгнэлтээс харж болохоор байна.

Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн төсөлд хийсэн аудитын дүгнэлт

2019 оны төсвийн төслийн аудитаар илэрсэн цаашид анхаарах асуудал:

- Хөтөлбөрт суурилсан төсвийн төлөвлөлтийг эдийн засгийн зардлын зүйл ангитай уялдуулан хүрэх үр дүн, бодлого чиглэлийг баримталсан төсвийн төслийг боловсруулж байх;
- Улсын болон орон нутгийн төсөв хоорондын харилцааг боловсронгуй болгох;
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн Төсвийн ерөнхийлөн захирагчдын эрх хэмжээ гэх мэт асуудлыг нарийвчлан судалж, төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр эрх зүйн шинэчлэл хийх, үр дүнгийн гэрээнд тусгаж байх;
- Төсвийн тогтвортой, нэгдмэл байдлыг хангахад анхаарч, бүх шатны төсвийн төсөл боловсруулах, хэрэгжүүлэхэд хууль, тогтоомж, дүрэм, журмын шаардлагыг мөрдөх, хариуцлага тооцох механизмыг сайжруулах, үр дүнг тооцох;
- Зураг төсөвгүй, техник эдийн засгийн үндэслэлгүй төсөл арга хэмжээг төсөвт тусгахгүй байх, зөрчсөн албан тушаалтанд тооцох хариуцлагын арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг ач холбогдлоор нь эрэмбэлэн төсөвт тусгаж хэрэгжүүлэх, үр ашгийг тооцох, хяналтын тогтолцоог сайжруулж, нэгдсэн программ хангамжтай нэвтрүүлж, улс орон нутгийн түвшинд бодлого, төлөвлөлтийг нэгтгэх;
- Орон нутгийн шинж чанартай хөрөнгийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхгүй байх.

Төсвийн хариуцлагыг дээшлүүлэх, техник, эдийн засгийн үндэслэлгүй төсөл арга хэмжээг төсөвт тусгахгүй байх, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ач

холбогдлоор нь эрэмбэлэх гэх мэтээр 2019 оны төсөвт зөвлөмж өгсөн байгаа нь 2020, 2021 онд мөн давтагджээ.

Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн төсөлд хийсэн аудитын дүгнэлт

- Цаашид жилийн төсвийн төсөл боловсруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд бүрэн нийцүүлж байх нь зүйтэй.
- Эрүүл мэндийн салбарт иргэнээ дагасан, гүйцэтгэлд суурилсан санхүүжилт олгох, мөн боловсролын салбарт төсвийн санхүүжилттэй холбоотой цахим шинэчлэлийг эхлүүлэхээр байгаа нь төсвийн удирдлагын оновчтой тогтолцооны эхлэл болохоор байна.
- Төрийн байгууллагуудын бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг татварын цахим төлбөрийн баримтын системд бүрэн холбож, цахимжуулан татварын орлогыг нэмэгдүүлэх боломжтой.
- Төсвийн төсөлд халамжийн зардлыг өмнөх оны төлөвлөсөн дүнгээс бууруулж байгаа ч цаашид халамжийн бодлогыг тэлэхгүй байх, нэр төрлийг нэгтгэн шалгуур үзүүлэлт, аргачлалыг оновчтой болгон зорилтот бүлэгт чиглэсэн бодлогыг хэрэгжүүлж, төсвийн үр нөлөөг сайжруулах шаардлагатай.
- Төсвийн байгууллагын сургалт семинар, хурал зөвлөгөөн, гадаад дотоод албан томилолтыг цахимаар зохион байгуулан, төрөөс иргэд, аж ахуйн нэгжүүдэд үзүүлдэг бүх төрлийн үйлчилгээ, тусгай зөвшөөрөл олголт, халамжийн цахим систем бий болгож зардлыг бууруулах боломжтой.
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг иргэдийн саналд үндэслэн тухайн орон нутгийн онцлогт нийцсэн хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг бүсчлэн байгуулах төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд чиглүүлэх шаардлагатай байна.
- Төсвийн төсөлд шинээр хэрэгжүүлэх 55 барилга, байгууламжийн зураг төсвийг батлуулаагүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл тусгасанд анхаарч, төсвийн төлөвлөлтийн хариуцлагын талаарх эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагатай.
- Цар тахлын эрсдэл бүхий нөхцөлд хэрэгжих 2021 оны төсвийн төсөлд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ач холбогдол, зориулалт, хэрэгцээ, шаардлагаар нь эрэмбэлэн санхүүжүүлэх асуудлыг журамлан зохицуулах нь зүйтэй.
- Засгийн газрын гадаад өрийн зохистой түвшнийг баримтлах, гадаад зээлээр үр ашиг бүхий төслийг санхүүжүүлэн тогтвортой хөгжих нөхцөлийг бий болгоход хөгжлийн болон төсвийн бодлогыг чиглүүлэх шаардлагатай.

2019 онд техник, эдийн засгийн үндэслэлгүй төсөл арга хэмжээг төсөвт тусгахгүй байх гэсэн зөвлөмж өгсөн байхад 2021 оны төсвийн төсөлд шинээр хэрэгжүүлэх 55 барилга байгууламжийн зураг төсвийг батлуулаагүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл тусгасан байгааг анхаарах

талаар зөвлөмж өгөгдсөн байна. Мөн 2019 онд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ач холбогдлоор нь эрэмбэлэх зөвлөмж өгсөн нь 2021 онд давтагдсан.

Нэгдсэн төсвийн төсөлд хийсэн аудитын зөвлөмжөөс хамгийн их давтамжтайг нэгтгэн Зураг 17-д харуулав.

Зураг 17. Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн төсөлд хийсэн аудитын дүгнэлт



- Орлогыг бодитой төлөвлөх, Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн хувьцааны ногдол ашгийг бүрэн ногдуулснаар төсөвт төвлөрүүлэх орлогыг нэмэгдүүлэх боломжтой;
- Зардлыг эрэмбэлж, үр ашиггүй урсгал зардлын тэлэлтийг хязгаарлаж, өмнөх түвшнээс нэмэгдүүлэхгүй байх замаар төсвийн алдагдлыг бууруулах боломжтой;
- Төрийн албан хаагчийн орон тоо, цалингийн сангийн нэгдсэн цахим систем бий болгож, зардал хэмнэх боломжтой;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний өртөгт хязгаар тогтоох, тавигдах шалгуурыг илүү тодорхой болгох шаардлагатай;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтын үр өгөөжийг дээшлүүлэхэд хяналтыг сайжруулах шаардлагатай.

ГҮЙЦЭТГЭЛИЙН БА НИЙЦЛИЙН АУДИТ

Гүйцэтгэлийн ба нийцлийн аудитын зөвлөмжийн хэрэгжилт сул байгаа ба аудитын тоо жил бүр буурсаар байна.

Зураг 18. Гүйцэтгэл, нийцлийн аудитын тоо, 2013-2020 он



2013 онд гүйцэтгэлийн аудитыг хамгийн олон (311) хийсэн бол 2020 онд хамгийн бага (58) хийжээ. Харин нийцлийн аудит 2016 онд 219 хийгдэж байсан бол 4 жилийн дараа буюу 2020 онд бараг 6 дахин цөөрч 39 болжээ.

Түүнчлэн нийцлийн болон гүйцэтгэлийн аудитын дүнгийн ил тод байдал хангагдахгүй байна. Энэ нь төсөв захирагчид санхүүгийн аудитын мэдээ л шилэн дансны цахим хуудсанд тавигдана гэж үздэгтэй холбоотой. Мөн эдгээрийг мэдээлэх албан ёсны суваг нь зөвхөн байгууллагын цахим хуудас

гэж үздэг, байгууллагын цахим хуудсанд гүйцэтгэл, нийцлийн аудитын талаар мэдээлэл тавигддаггүйтэй холбоотой.

Төслийн хугацаанд бид төрийн аудитын дүгнэлт, зөвлөмж, төсвийн мэдээлэл, дүн шинжилгээг олон нийтэд тогтмол хүргэж ажиллалаа. Энэ хүрээнд sinaudit.mn цахим хуудас ажиллуулснаас гадна “Сайн аудит” Facebook, “Аудитын тухай ярилцъя” Twitter болон Instagram хуудсуудыг хөтлөв. Эдгээрт 2017 оны улсын болон орон нутгийн аудит, Аудитын зөвлөмжийн хэрэгжилт

аймаг тус бүрээр (2018), Санхүүгийн Аудитын биелэлт (2017), Орон нутгийн аудит бүсчлэлээр (2018), ТЕЗ-дын 2018 оны төсвийн санхүүгийн аудит, Төрийн өмчит үйлдвэрийн газруудын 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудит, Нийцлийн аудит (2018), Нийслэл (2018), Аудитын дүгнэлтийн ил тод байдал (2018, 2019), Монгол Улсын 2018, 2019 оны төсвийн гүйцэтгэл, Монгол Улсын 2019, 2020 оны нэгдсэн төсвийн төсөлд хийсэн аудит, 2021 оны нэгдсэн төсвийн төсөлд хийсэн аудит, ТЕЗ-дын давтан гаргасан алдаа, зөрчил (2016-2018), ТЕЗ-дын давтан гаргасан алдаа, зөрчил (2019), Аудитын үйл ажиллагаа зэрэг агуулгын хүрээнд мэдээлэл нийтэллээ. Мөн “Төсвийн хяналтад аудитын зөвлөмжийн хэрэгжилт” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулж ТББ, иргэд, хэвлэлийн төлөөллийг оролцуулснаас гадна хэвлэлийн цуврал

хурал хийж, телевизүүдэд төсвийн хяналт, аудитын хэрэгжилтийн талаар ярилцлага өгч ажиллалаа.

Мониторингийн хүрээнд явуулсан үйл ажиллагааны дүнд аудитын зөвлөмжийн хэрэгжилт, тэдгээрийн ил тод байдлыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулснаас гадна олон нийтийг төрийн аудит, төсвийн үнэн зөв мэдээллээр хангахад анхаарч, оролцоог дэмжиж ажиллав. 2019-2020 онд иргэд улсын төсвийн талаар сонирхох болж, оролцоо нэмэгдэж байгаа нь мэдээллийн хэрэгслүүдээр явж байгаа мэдээ мэдээллээс харахад илэрхий болсон. Цаашилбал, төрийн байгууллага, олон нийтийн эерэг харилцаа, уур амьсгалд тодорхой хэмжээнд хувь нэмэр оруулсан гэж үзэж буй. Тухайлбал, төсвийн байгууллагууд манай зүгээс хүргүүлсэн албан тоотод хариу өгч, хамтран ажилладаг болсон.

МОНИТОРИНГИЙН ДҮГНЭЛТ

Үнэн Хатамж ТББ нь “Аудитын зөвлөмж, дүгнэлтийн хэрэгжилт, үр дүнгийн мониторинг” төслийн хүрээнд 2019-2020 онд хийсэн ажлын дүнд дараах дүгнэлт гаргаж байна. Үүнд:

- Зөвлөмжийн хэрэгжилтийн хувьд санхүүгийн аудит 80-аас дээш хувьтай байгаа бол нийцлийн болон гүйцэтгэлийн аудитын зөвлөмжийн хэрэгжилт сул (40-60 хувь) байна. Мөн гүйцэтгэлийн ба нийцлийн аудитын тоо жил бүр буурсаар байна.
- Зөрчил, алдаа давтагдсаар байна. Төсөв захирагчдын алдаа зөрчил 2-3 жил дараалан давтагдаж байгаа нь зөвлөмжийн хэрэгжилтийг сайжруулах шаардлагатайг харуулна.
- Төсвийн шууд захирагчдын хувьд зөвлөмжийн хэрэгжилт харьцангуй сайн, төсвийн хэмжээндээ зарцуулалт хэвийн, акт тогтооход төлөлт сайн байгаа нь харагдав. Харин ТЕЗ-дын хувьд хэрэгжилт сул байна. Тухайлбал, жил бүрийн улсын төсвийн төлөвлөлтөд аудит хийж Ерөнхий сайд, Сангийн сайдад өгсөн зөвлөмжүүд биелэгдэхгүй зөрчил давтагдсаар байна.
- ТЕЗ-дад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах зөвлөмж өгдөг ч жил дараалан хэрэгжихгүй байна.
- Аудитаар жилдээ улсын төсөвтэй тэнцэхүйц мөнгөн дүн бүхий зөрчил илрээд байгаа нь төсвийн хяналтыг сайжруулах, иргэний нийгмийн байгууллага, иргэдийг хяналтад татан оруулах шаардлагатайг харуулж байна.

МОНИТОРИНГИЙН ЗӨВЛӨМЖ

Мониторингийн үйл ажиллагааны дүнд үндэслэн төсвийн удирдлагын ил тод байдал, түүнд тавих хяналтыг сайжруулах чиглэлээр дараах зөвлөмжийг гаргаж байна.

- “Монгол Улсын Ерөнхий аудитор төрийн санхүү, төсөв, нийтийн өмчийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөө өгөхүйц төлөвлөх, хуваарилах, ашиглах, захиран зарцуулахад хамаарах аливаа асуудлаар санал, зөвлөмж бэлтгэж, УИХ-д танилцуулж болно” гэсэн “Төрийн аудитын тухай” хуулийн 33.4 дэх заалтыг хэрэгжүүлэх. Энэ хүрээнд зөвлөмжийг нарийвчилсан байдлаар тодорхой өгдөг болох.
- Төрийн аудитын байгууллага олон тооны аудит хийж ажлын ачаалал ихтэй байдаг ч зөрчлөөс урьдчилан сэргийлэх, дүгнэлт зөвлөмжийн хэрэгжилтэд түлхүү анхаарч ажиллах. Уг ажлыг иргэд, олон нийт, ТББ-ын оролцоотой хийх боломжтой.
- Төрийн аудитын байгууллага санхүүгийн аудитаа ТЕЗ-дын дотоод хяналт, хувийн хэвшлийн аудитын компаниар гүйцэтгүүлж, стратегийн зөвлөмж, төсвийн төлөвлөлт, үр өгөөжийг дээшлүүлэхэд анхаарч, тоо нь буурсаар байгаа гүйцэтгэлийн, нийцлийн аудитыг түлхүү анхаарч ажиллах хэрэгтэй.
- ТЕЗ-дад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд анхааран ажиллах, авах арга хэмжээг дээшлүүлэх шаардлагатайг давтамжтайгаар сануулж байх нь зүйтэй.
- Засгийн газар төрийн аудитын байгууллагатай хамтран ажиллаж, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах талаар төсөв захирагчдад сануулж ажиллах, цаг хугацаандаа нийтлэгдээгүй байсан зөвлөмжийн хэрэгжилтийн мэдээлэл оны сүүлээр хугацаандаа нийтлэгдсэн мэт харагддаг алдааг гаргуулахгүй байх шаардлагатай.
- Гүйцэтгэлийн ба нийцлийн аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг дээшлүүлэх, энэ төрлийн аудит жил бүр буурсаар байгааг анхаарах нь зүйтэй.
- Нийцлийн болон гүйцэтгэлийн аудитын дүнгийн ил тод байдлыг хангах чиглэлээр арга хэмжээ авч, дүнг мэдээлэх суваг бий болгох, олон нийтэд хүргэх тал дээр анхаарч ажиллах нь зүйтэй.
- Сонгуулийн жилд Шилэн дансны болон төсвийн ил тод байдалтай холбоотой бусад хуулийн хэрэгжилт буурах хандлагатай байдгийг анхаарч, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах. Жишээ нь, шинээр сонгогдож буй Засгийн Газрын гишүүн, сайд нарт шилэн дансны цахим хуудас, төсвийн хяналтын талаар мэдээлэл даруй хүргэх хэрэгтэй.
- Аудитын тухай ойлголт, зөвлөмж, дүгнэлтийн хэрэгжилтийг сайжруулах хүрээнд авч буй арга хэмжээ болон алдаа дутагдлаас урьдчилан сэргийлэх хүрээнд иргэд, ТББ-тай хамтран ажиллах.